



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

2026 оны 04 дүгээр сарын 13
№15 (1410)

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠬᠡ ᠬᠤᠷᠭᠢᠨ ᠠᠯᠪᠠᠨ
ᠮᠡᠳᠡᠭᠡᠯᠡᠯ



ГАРЧИГ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

- | | | | |
|-----|---|-----------|-----|
| 48. | Монгол Улсын Их Хурлын даргыг
сонгох тухай | Дугаар 06 | 751 |
|-----|---|-----------|-----|

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

- | | | | |
|-----|----------------------------------|-----------|-----|
| 49. | Төлөвлөгөө шинэчлэн батлах тухай | Дугаар 11 | 753 |
|-----|----------------------------------|-----------|-----|



	<p>Тайлбар</p> <p>Үзүүлэлт өсөхөд хүргэх үйлдлийн үр дүнд Үзүүлэлт өсөхөд хүргэх үйлдлийн үр дүнд Үзүүлэлт өсөхөд хүргэх үйлдлийн үр дүнд Үзүүлэлт өсөхөд хүргэх үйлдлийн үр дүнд</p>	<p>0.14</p> <p>0.14</p>
--	---	-------------------------



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2026 оны 04 дүгээр
сарын 03-ны өдөр

Дугаар 06

Улаанбаатар
хот

Монгол Улсын Их Хурлын даргыг сонгох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1, 11.3 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Монгол Улсын Их Хурлын даргаар Улсын Их Хурлын гишүүн Сандагийн Бямбацогтыг сонгосугай.

2.Энэ тогтоолыг 2026 оны 04 дүгээр сарын 03-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДЭД ДАРГА**

Ж.БАТ-ЭРДЭНЭ



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2026 оны 01 дүгээр
сарын 14-ний өдөр

Дугаар 11

Улаанбаатар
хот

Төлөвлөгөө шинэчлэн батлах тухай

Гамшгаас хамгаалах тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1.2 дахь заалтыг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1.“Монгол Улсын гамшгаас хамгаалах төлөвлөгөө”-г хавсралт ёсоор шинэчлэн баталсугай.

2.Монгол Улсын гамшгаас хамгаалах төлөвлөгөөг хэрэгжүүлэх арга хэмжээ авч ажиллахыг Монгол Улсын Шадар сайд Х.Ганхуягт үүрэг болгосугай.

3.Энэ тогтоол гарсантай холбогдуулан “Төлөвлөгөө батлах тухай” Засгийн газрын 2015 оны 10 дугаар сарын 19-ний өдрийн 416 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

Г.ЗАНДАНШАТАР

**МОНГОЛ УЛСЫН
ШАДАР САЙД**

Х.ГАНХУЯГ

Засгийн газрын 2026 оны 01 дүгээр сарын 14-ний өдрийн 11 дүгээр тогтоолын хавсралт

МОНГОЛ УЛСЫН ГАМШГААС ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Үндэслэл

Монгол Улсад төдийгүй дэлхий нийтэд уур амьсгалын өөрчлөлт, хүний буруутай үйл ажиллагааны улмаас байгаль цаг уур, биологийн гаралтай аюулт үзэгдэл, гамшиг, ослын төрөл, тоо, давтамж, түүнээс учрах хохирол жил бүр өсөн нэмэгдэж, улс орны нийгэм, эдийн засгийн хөгжил, хүний эрүүл мэнд, амь нас, амьжиргаанд сөрөг нөлөө үзүүлж байна.

Уур амьсгалын өөрчлөлтөөс бий болсон шинэ нөхцөлд дасан зохицох, олон нийтийн оролцоонд тулгуурлан гамшгийн эрсдэлийг бууруулах, бэлэн байдлыг хангах, салбар дундын харилцан ажиллагаа, үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэх, удирдлага, зохицуулалтыг сайжруулах, гамшгаас хамгаалах төлөвлөлтийг боловсронгуй болгох замаар гамшиг, ослыг хохирол багатай даван туулах, гамшгийг сөрөн тэсвэрлэх үндэсний чадавхыг бэхжүүлэх шаардлага тавигдаж байна.

Дээр дурдсан үндэслэл, шаардлагыг харгалзан Монгол Улсын Үндсэн хууль, Гамшгаас хамгаалах тухай хууль тогтоомж, Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенц болон бусад холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн Монгол Улсын гамшгаас хамгаалах төлөвлөгөөг боловсрууллаа.

1.2.Зорилго

Гамшгаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах, бэлэн байдлыг хангах, гамшгийн үед эрэн хайх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох, хүмүүнлэгийн тусламж зохион байгуулах арга хэмжээг удирдлага, зохион байгуулалтаар хангахад оршино.

1.3.Хамрах хүрээ:

1.3.1.Энэхүү төлөвлөгөөг улсын хэмжээнд, эсхүл нийслэл болон хэд хэдэн аймгийн нутаг дэвсгэрийг хамарсан гамшгийн нөхцөл байдал үүссэн үед хэрэгжүүлнэ;



1.3.2. Монгол Улсын гамшгаас хамгаалах төлөвлөгөө нь Улсын Их Хурал, Үндэсний аюулгүй байдлын зөвлөл, Засгийн газар, Гамшгийн эрсдэлийг бууруулах үндэсний зөвлөл, Онцгой байдлын байгууллага, бүх шатны онцгой комисс, гамшгаас хамгаалах улсын алба, төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагууд, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, хуулийн этгээдийн гамшгаас хамгаалах үйл ажиллагааг хэрэгжүүлэх харилцааг зохицуулна;

1.3.3. Энэхүү төлөвлөгөөг үндэслэн доор дурдсан салбар төлөвлөгөөг нарийвчлан боловсруулж, хэрэгжүүлж ажиллана;

Дугаар (Код)	Чиглэл	Хариуцах байгууллага	Батлах албан тушаалтан
Код-1	Газар хөдлөлтийн гамшгийн төлөвлөгөө	Онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага	Монгол Улсын Шадар сайд бөгөөд Улсын онцгой комиссын дарга
Код-2	Хүний гоц халдварт өвчин, цар тахлын хариу арга хэмжээний төлөвлөгөө	Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага	
Код-3	Зудын гамшгийн хариу арга хэмжээний төлөвлөгөө	Хүнс, хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага	
Код-4	Үерийн гамшгийн хариу арга хэмжээний төлөвлөгөө	Барилгын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага	
Код-5	Ой, хээрийн түймрийн хариу арга хэмжээний төлөвлөгөө	Онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага	
Код-6	Мал, амьтны гоц халдварт өвчний хариу арга хэмжээний төлөвлөгөө	Хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага	
Код-7	Нүүлгэн шилжүүлэх төлөвлөгөө	Онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага	
Код-8	Хүч хэрэгсэл дайчлан гаргах төлөвлөгөө		
Код-9	Хүмүүнлэгийн тусламжийн төлөвлөгөө		
Код-10	Гамшгаас хамгаалах улсын болон орон нутгийн албаны гамшгаас хамгаалах төлөвлөгөө	Гамшгаас хамгаалах алба	Гамшгаас хамгаалах албаны дарга
Код-11	Нийслэлийн гамшгаас хамгаалах төлөвлөгөө	Нийслэлийн Засаг даргын Тамгын газар	Нийслэлийн онцгой комиссын дарга

Код-12	Аймгийн гамшгаас хамгаалах төлөвлөгөө	Аймгийн Засаг даргын Тамгын газар	Аймгийн онцгой комиссын дарга
Код-13	Сум, дүүргийн гамшгаас хамгаалах төлөвлөгөө	Сум, дүүргийн Засаг даргын Тамгын газар	Сум, дүүргийн онцгой комиссын дарга
Код-14	Аж ахуйн нэгж, байгууллагын гамшгаас хамгаалах төлөвлөгөө	Хуулийн этгээд	Хуулийн этгээдийн дарга, захирал

1.3.4.Салбар төлөвлөгөөг боловсруулахад Онцгой байдлын байгууллагаас арга зүйн зөвлөгөө, зааварчилгаа өгч, мэргэжлийн удирдлагаар ханган ажиллана.

Хоёр.Гамшгийн эрсдэлийг бууруулах, урьдчилан сэргийлэх арга хэмжээ

Үндэслэл:Гамшгаас хамгаалах тухай хуулийн 9, 22, 27, 29, 32, 33, 34 дүгээр зүйл, Засгийн газрын 2017 оны 355 дугаар тогтоолоор баталсан “Гамшгийн эрсдэлийг бууруулах Сендайн үйл ажиллагааны хүрээг Монгол Улсад хэрэгжүүлэх дунд хугацааны стратеги”.

2.1.Гамшгийн эрсдэлийг бууруулах, урьдчилан сэргийлэх чиглэлээр дараах арга хэмжээг хэрэгжүүлнэ:

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжүүлэх байгууллага
1.	<ul style="list-style-type: none"> - Бодлого, төлөвлөлтийн баримт бичигт гамшгийн эрсдэлийг тооцох, эрсдэлийг бууруулах зорилт, үйл ажиллагаа болон шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг тусгах талаар зөвлөмж өгөх, удирдамж гаргах; - Гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагаанд төр, хувийн хэвшлийн түншлэл, хамтын ажиллагаа, иргэд, олон нийтийн оролцоог хангах; - Гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагаанд шинжлэх ухаан, техник, технологийн шинэ ололт, инновацыг нэвтрүүлэх талаар чиглэл өгөх; - Засгийн газрын тогтоолоор баталсан “Гамшгийн эрсдэлийг бууруулах үндэсний зөвлөлийн ажиллах журам”-д заасан арга хэмжээг хэрэгжүүлэх. 	Гамшгийн эрсдэлийг бууруулах үндэсний болон орон нутгийн зөвлөл (ГЭБҮЗ)



2.	<ul style="list-style-type: none"> - Гамшгаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах нэгдсэн арга хэмжээний удирдамж боловсруулж хэрэгжүүлэх; - Гамшгаас хамгаалах улсын хяналтыг хэрэгжүүлэх; - Гамшгаас хамгаалах сургалтыг төлөвлөн зохион байгуулах; - Гамшгаас хамгаалах төлөвлөгөө боловсруулахад мэргэжил, арга зүйн зөвлөмж өгөх, хянах; - Гамшгаас хамгаалах бэлэн байдлын үзлэгийг зохион байгуулах; - Иргэдийг нүүлгэн шилжүүлэх түр байр, түр цугларах талбайн томилгоожуулалтад хяналт тавих; - Гамшгийн үед хэрэглэх хүнс, бараа материалын нөөц бүрдүүлэх, орон нутгийн нөөц бүрдүүлэлтэд хяналт тавих; - Гамшгаас хамгаалах хүч хэрэгслийн бэлэн байдлыг хангах. 	<p>Онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага (ОБАЭТЗБ)</p>
3.	<ul style="list-style-type: none"> - Байгаль, цаг агаарын гамшигт болон аюулт үзэгдлийн тухай урьдчилсан мэдээ, мэдээлэл, сансрын хиймэл дагуулын үзэгдлийн зураглал гаргах, олон нийт, иргэдэд мэдээлэх; - Гамшгийн эрсдэлийг бууруулах, урьдчилан сэргийлэх арга хэмжээг төлөвлөх, хэрэгжүүлэх; - Байгаль, цаг агаарын гаралтай гамшигт болон аюулт үзэгдлийн нөлөөллийн үнэлгээг тухай бүр хийж урьдчилан сэргийлэх, холбогдох байгууллагыг мэдээллээр хангах; - Улсын хил дагуу болон хилийн боомтод ой, хээрийн гал түймрээс хамгаалах зурвас байгуулах, сэргээх; - Химийн хорт болон аюултай бодис алдагдахаас урьдчилан сэргийлэх сургалт, сурталчилгааны ажлыг зохион байгуулах; - Химийн хорт болон аюултай бодис ашиглах, хадгалах, худалдах, тээвэрлэх үйл ажиллагаа явуулдаг тусгай зөвшөөрөл бүхий хуулийн этгээдийн үйл ажиллагаанд хяналт тавих; - Химийн хорт болон аюултай бодистой холбоотой журам, заавар, стандартыг боловсруулж, ослын эрсдэлийн зураглал гаргах, аж ахуйн нэгж, байгууллагын судалгааг гаргаж, мэдээллийн сан бүрдүүлэх; - Ой, хээрийн гал түймрийн эрсдэлийн түвшин өндөр бүс нутагт зорчих хөдөлгөөн, зарим үйл ажиллагааг хязгаарлах, хөдөлгөөнт болон байнгын эргүүл, хяналтын цэг ажиллуулж сэрэмжлүүлэг, мэдээллийг иргэдэд өгөх; - Ой, хээрийн бүс нутагт ус цуглуулах далан, худаг зэрэг усны эх үүсвэрийг байгуулах; - Гамшгаас хамгаалах тухай хуулийн 33 дугаар зүйлд тусгагдсан чиг үүргийг хэрэгжүүлэх. 	<p>Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага (БОАЭТЗТБ)</p>

<p>4.</p>	<ul style="list-style-type: none"> - Хүний гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах; - Гамшгийн эрсдэлийг бууруулах, урьдчилан сэргийлэх арга хэмжээг төлөвлөх, хэрэгжүүлэх; - Гамшиг, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үед үзүүлэх эрүүл мэндийн тусламж үйлчилгээний бэлэн байдал, хариу арга хэмжээг тухай бүрд үнэлэн, зөвлөмж боловсруулах; - Хүний гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, тэмцэх чиглэлээр холбогдох байгууллагуудтай харилцан ажиллах төлөвлөлтийг боловсруулах; - Гамшгийн үед нэрвэгдэгсэд иргэдэд эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлэх, хээрийн эмнэлэг дэлгэх бэлтгэлийг хангах, шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмж, цус, цусан бүтээгдэхүүний нөөц бүрдүүлэх; - Хэвлэл, мэдээллийн хэрэгсэл, багц мессежээр урьдчилан сэргийлэх мэдээ, мэдээллийг хүргэх; - Салбар хоорондын хамтарсан дадлага сургуулилт зохион байгуулах; - Гамшгаас хамгаалах тухай хуулийн 33 дугаар зүйлд тусгагдсан чиг үүргийг хэрэгжүүлэх. 	<p>Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага (ЭМАЭТЗТБ)</p>
<p>5.</p>	<ul style="list-style-type: none"> - Хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний нөөцийг улсын хэмжээнд нэгтгэн тодотгох; - Гамшгийн эрсдэлийг бууруулах, урьдчилан сэргийлэх арга хэмжээг төлөвлөх, хэрэгжүүлэх; - Үр тариа, төмс, хүнсний ногоо, тэдгээрийн шилмэл сорт, бэлчээрийг ургамлын хортон шавж, цацраг, химийн хордолт, биологийн халдвараас хамгаалах арга хэмжээг зохион байгуулах; - Өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах арга хэмжээг төлөвлөх, хэрэгжүүлэх; - Отроор өвөлжих малчин өрх, малын тоо, отрын талбайн зураглалыг гаргах, тухайн орон нутгийн засаг захиргаатай отрын гэрээ байгуулах ажлыг удирдлагаар хангах; - Малчин өрхийн нарийвчилсан судалгаа гаргах; - Малчид, тариаланчдад гамшгаас хамгаалах чиглэлээр сургалт зохион байгуулах; - Худаг, уст цэгийг сэргээх, шинээр нэмж байгуулах; - Мал, амьтан, ургамлын гаралтай хүнсний болон хүнсний бус түүхий эдийн эрүүл ахуй, ариун цэврийн шаардлагыг хангуулах; - Мал, амьтны гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэх; - Мал, амьтны гоц халдварт өвчний бүртгэл, тархвар зүйн судалгааг гаргах; - Гамшгаас хамгаалах тухай хуулийн 33 дугаар зүйлд тусгагдсан чиг үүргийг хэрэгжүүлэх. 	<p>Хүнс, хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага (ХХАААЭТЗТБ)</p>



6.	<ul style="list-style-type: none"> - Гамшгийн эрсдэлийг бууруулах, урьдчилан сэргийлэх арга хэмжээг төлөвлөх, хэрэгжүүлэх; - Гамшиг, аюулт үзэгдэл, ослоос урьдчилан сэргийлэх сэрэмжлүүлэг, мэдээг хэвлэл, мэдээллийн хэрэгсэл, олон нийтийн цахим сүлжээ, багц мессежээр хүртээмжтэй хүргэх нөхцөлийг бүрдүүлэх; - Богино долгионы радио холбооны улсын нэгдсэн сүлжээг зохион байгуулах, радио станцаар хангах; - Гамшгийн үед мэдээ, мэдээлэл дамжуулах, солилцох интернэт, сүлжээгээр хангах тоног төхөөрөмжийг бэлтгэх, радио холбоогоор хангах нөхцөлийг бүрдүүлэх; - Улсын харилцаа холбоо, мэдээллийн хэрэгслийг байнгын бэлэн байдалд байлгах арга хэмжээг авч хэрэгжүүлэх; - Гамшгийн үед үүрэн холбооны операторуудтай хамтран ажиллах зохицуулалт хийх; - Гамшгаас хамгаалах тухай хуулийн 33 дугаар зүйлд тусгагдсан чиг үүргийг хэрэгжүүлэх. 	<p>Харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага (ХХАЭТЗТБ)</p>
7.	<ul style="list-style-type: none"> - Гамшгийн эрсдэлийг бууруулах, урьдчилан сэргийлэх арга хэмжээг төлөвлөх, хэрэгжүүлэх; - Хот, суурин газрын газар хөдлөлтийн бичил мужлалын зургийн дагуу барилга байгууламжийн газар хөдлөлтийг тэсвэрлэх чанарыг үнэлэх, нэгдсэн судалгаа гаргах, паспортжуулах; - Ашиглалтын шаардлага хангахгүй барилгыг хүчитгэх, буулгаж шинээр барих ажлыг үе шаттай төлөвлөх, холбогдох зардлыг шийдвэрлэх, төсөвт тусгах, шуурхай зохион байгуулах; - Хот, суурин газрын ерөнхий болон хэсэгчилсэн төлөвлөлтөд гамшгийн эрсдэлийг тооцох, далан, суваг, шуудуу, инженерийн байгууламжийг гамшигт тэсвэртэй байдлаар төлөвлөх; - Гамшгаас хамгаалах үйл ажиллагаатай холбоотой дүрэм, журам, заавар стандартыг баталж, мөрдүүлэх. 	<p>Хот байгуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага (ХБАЭТЗТБ)</p>
8.	<ul style="list-style-type: none"> - Гамшгийн эрсдэлийг бууруулах, урьдчилан сэргийлэх арга хэмжээг төлөвлөх, хэрэгжүүлэх; - Эрчим хүчний байгууламж, дэд бүтцийг сэргээх, засварлах тусгай зориулалтын тоног төхөөрөмж, аюул, ослын үед ажиллахад шаардагдах нөөцийг бүрдүүлэх; - Түлш, эрчим хүчний үйлдвэрүүдэд техникийн үүдэлтэй ослоос урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулах; - Эрчим хүч, дулаанаар хангахад шаардлагатай нөөц бүрдүүлэх, бэлэн байдлыг хангах; - Цахилгааны шугам сүлжээний аюулгүй байдлыг хангахтай холбоотой дүрэм, журам, стандартыг баталж мөрдүүлэх; - Гамшгаас хамгаалах тухай хуулийн 33 дугаар зүйлд тусгагдсан чиг үүргийг хэрэгжүүлэх. 	<p>Эрчим хүчний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага (ЭХАЭТЗТБ)</p>

9.	<ul style="list-style-type: none"> - Гамшгийн эрсдэлийг бууруулах, урьдчилан сэргийлэх арга хэмжээг төлөвлөх, хэрэгжүүлэх; - Гамшгийн үед зам сэргээн засах бүлгүүдийг урьдчилан томилгоожуулах; - Гамшгийн үед авто зам даваа хаагдах, хүндрэл үүссэн үед ажиллах шуурхай ажлын хэсгүүдийн бэлтгэл, бэлэн байдлыг хангах (туулах чадвар сайтай тээврийн хэрэгсэл, цас цэвэрлэх механизм, зам гаргагч /дальпуу/ зэрэг техник хэрэгслийн бэлэн байдлыг хангаж, элс, давс, бодисын нөөц бүрдүүлэх, машин механизмаар дэмжлэг үзүүлэх); - Дэд бүтцийг сэргээх, засварлах тусгай зориулалтын тоног төхөөрөмж, аюул, ослын үед ажиллахад шаардагдах хүч, хэрэгслийн тооцоо судалгааг гаргах; - Иргэдийг агаар, төмөр зам болон авто замаар нүүлгэн шилжүүлэх бэлтгэлийг хангах; - Гамшгийн үед олон улсын эрэн хайх, аврах баг болон хүмүүнлэгийн тусламжийг хүлээн авах, шилжүүлэн байрлуулах, нисэх буудлын үндсэн үйл ажиллагааг алдагдуулахгүй зохион байгуулах арга хэмжээг төлөвлөх, бэлтгэл хангах, дадлага сургууль зохион байгуулах; - Аюултай ачаа тээврийн хөдөлгөөний цагийн хуваарь, маршрутад урьдчилан зохицуулалт хийх, стандартыг чанд мөрдүүлэх; - Гамшгаас хамгаалах тухай хуулийн 33 дугаар зүйлд тусгагдсан чиг үүргийг хэрэгжүүлэх. 	<p>Зам, тээврийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага (ЗТХАЭТЗТБ)</p>
10.	<ul style="list-style-type: none"> - Гамшгийн эрсдэлийг бууруулах, урьдчилан сэргийлэх арга хэмжээг төлөвлөх, хэрэгжүүлэх; - Гамшгийн үед хүнд машин механизмыг татан оролцуулах бэлтгэл хангах, урьдчилан томилгоожуулах; - Улсын хэмжээнд шатахуун хангамж, нийлүүлэлт, тээвэрлэлт, түгээлт, нөөцийн тогтвортой байдлыг хангах, нөөцийг нэмэгдүүлэх; - Уурхай, уулын үйлдвэр эрхэлдэг, тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл импортлох, үйлдвэрлэх, хадгалах, худалдаалах, тэсэлгээний ажил явуулдаг хуулийн этгээдэд гамшгийн эрсдэлийн нарийвчилсан үнэлгээ хийлгэх; - Уул уурхайн зориулалт бүхий цацраг, хими, тэсэрч дэлбэрэх бодисын аюулгүй байдалд хяналт тавих, шаардлагатай мэдээллээр бусад яам, агентлагийг хангах; - Томоохон уул уурхайн үйлдвэрүүдийн гал унтраах болон аврах нэгжүүдийг чадавхжуулж, мэргэжлийн байгууллагатай хамтарсан сургалт, дадлага зохион байгуулах; - Гамшгаас хамгаалах тухай хуулийн 33 дугаар зүйлд тусгагдсан чиг үүргийг хэрэгжүүлэх. 	<p>Геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага (ГУУАЭТЗТБ)</p>



11.	<ul style="list-style-type: none"> - Гамшгийн үед хүүхэд, жирэмсэн эх, өндөр настан, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн судалгаа гаргах, аюулгүй байдлыг хангах бүлгийг урьдчилан томилгоожуулах, сургалт зохион байгуулах, нийгмийн халамж, төрийн үйлчилгээг тасалдалгүй хүргэх урьдчилсан төлөвлөлт хийх; - Гамшгийн эрсдэлийг бууруулах, урьдчилан сэргийлэх арга хэмжээг төлөвлөх, хэрэгжүүлэх; - Гамшгийн голомтод үүрэг гүйцэтгэх томилгоот бүрэлдэхүүний хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйг хангах; - Гамшиг, осол, аюулт үзэгдлийн талаар мэдээ, мэдээллийг хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд тохирсон хэлбэрээр хүргэх бэлтгэл хангах; - Гамшгаас хамгаалах тухай хуулийн 33 дугаар зүйлд тусгагдсан чиг үүргийг хэрэгжүүлэх. 	<p>Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн төв байгууллага (ГБХНХАЭТЗТБ)</p>
12.	<ul style="list-style-type: none"> - Гамшгийн тухай зарлан мэдээллийн болон сэрэмжлүүлэх дохио, урьдчилан сэргийлэх мэдээ, мэдээллийг хэвлэл, мэдээллийн хэрэгсэл, олон нийтийн цахим сүлжээ, багц мессежээр хүргэх бэлтгэл хангах; - Гамшгийн эрсдэлийг бууруулах, урьдчилан сэргийлэх арга хэмжээг төлөвлөх, хэрэгжүүлэх; - Олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр гамшгийн эрсдэлийг бууруулах, урьдчилан сэргийлэх сэрэмжлүүлэг мэдээлэл, сурталчилгааг тогтмол олон нийтэд хүргэх ажлыг зохион байгуулах; - Гамшгаас хамгаалах тухай хуулийн 33 дугаар зүйлд тусгагдсан чиг үүргийг хэрэгжүүлэх. 	<p>Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах газар (ЗГХЭГ-ын ХМОНХГ)</p>
13.	<ul style="list-style-type: none"> - Ажилтан, алба хаагчиддаа гамшгаас хамгаалах сургалт зохион байгуулах; - Гамшгаас хамгаалах үйл ажиллагааны талаарх хууль тогтоомж, дүрэм, журам, зааврыг боловсруулахад мэргэжил, арга зүйн зөвлөмж өгөх; - Монгол Улсад оршин суугаа гадаадын иргэн, харьяалалгүй хүмүүсийн судалгаа, мэдээллийг гаргах (Гадаадын иргэн, харьяатын газар); - Гамшгийн үед Монгол Улсаас өөрийн оронд буцах хүсэлтэй гадаадын иргэдийг хүмүүнлэгийн шугамаар буцаах ажлыг төлөвлөх (Гадаадын иргэн, харьяатын газар). 	<p>Хууль зүйн асуудал эрхэлсэн төв байгууллага (ХЗАЭТЗТБ)</p>

14.	<ul style="list-style-type: none"> - Гамшгийн үед Монгол Улс дахь дипломат төлөөлөгчийн газар, олон улсын байгууллагын төлөөлөгчийн газарт мэдээ, мэдээлэл хүргэх боломжийг урьдчилан бүрдүүлэх; - Гадаад улс дахь Монгол Улсын иргэдийн судалгаа гаргах, гамшгийн үед татан авах төлөвлөлт хийх, бэлтгэлийг хангах; - Гадаад улсын цэргийн тусламжийг хүлээн авах асуудлыг холбогдох байгууллагатай хамтран шийдвэрлүүлэх, удирдлага зохицуулалтаар хангах; - Олон улсын эрэн хайх аврах баг, хүмүүнлэгийн тусламжийг хүлээн авах зохион байгуулалтын арга хэмжээг төлөвлөх, бэлтгэлийг хангах. 	<p>Гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага (ГХАЭТЗТБ)</p>
15.	<ul style="list-style-type: none"> - Гамшгаас хамгаалах үйл ажиллагаатай холбоотой төсөв, санхүүгийн асуудлыг шийдвэрлэх; - Гамшгийн үед шаардлагатай хүнс, бараа, материалын нөөцийг бүрдүүлэх, холбогдох зардлыг шийдвэрлэх; - Гамшгаас хамгаалах тухай хуулийн 33 дугаар зүйлд тусгагдсан чиг үүргийг хэрэгжүүлэх. 	<p>Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага (СТАЭТЗТБ)</p>
16.	<ul style="list-style-type: none"> - Гамшгийн эрсдэлийг бууруулах, урьдчилан сэргийлэх арга хэмжээг төлөвлөх, хэрэгжүүлэх; - Гамшгийн үед түр орон байраар ашиглах боломжтой байруудын судалгааг гаргах; - Бүх шатны боловсролын байгууллагын суралцагчдад гамшиг, ослоос урьдчилан сэргийлэх сургалтыг насны ангилалд тохируулан сургалтын хөтөлбөрт тусгах, боловсролын байгууллагууд гамшгаас хамгаалах дадлага сургуулийг зохион байгуулах; - Гамшгаас хамгаалах тухай хуулийн 33 дугаар зүйлд тусгагдсан чиг үүргийг хэрэгжүүлэх. 	<p>Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага (БАЭТЗТБ)</p>
17.	<ul style="list-style-type: none"> - Улсын хөгжлийн урт, дунд, богино хугацааны бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, хөрөнгө оруулалтын нэгдсэн бодлогод гамшгаас хамгаалах үйл ажиллагааны чиглэлийг тусгах. 	<p>Үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага (ҮХБТАЭТЗТБ)</p>
18.	<ul style="list-style-type: none"> - Гамшгийн эрсдэлийг бууруулах, урьдчилан сэргийлэх арга хэмжээг төлөвлөх, хэрэгжүүлэх; - Газарзүйн мэдээллийн системийн хөгжүүлэлтийг тогтмол хийх; - Газрын мэдээллийн санд түр цугларах талбай, нүүн шилжих, нүүлгэн шилжүүлэх байршлын мэдээллийг тухай бүр бүртгэх; - Газар хөдлөлтийн бичил мужлалын зураглалыг мэргэжлийн байгууллагатай хамтран гаргах; - Үерийн эрсдэлтэй бүс нутгийн зураглалыг гаргах, эрсдэлтэй байршилд буусан иргэн, хуулийн этгээдэд албан шаардлага хүргүүлэх, мэдээ мэдээллээр хангах; - Гамшгаас хамгаалах тухай хуулийн 33 дугаар зүйлд тусгагдсан чиг үүргийг хэрэгжүүлэх. 	<p>Геодези, зураг зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага (ГЗЗАЭТЗБ)</p>



19.	<ul style="list-style-type: none"> - Гамшгийн эрсдэлийг бууруулах, урьдчилан сэргийлэх арга хэмжээг төлөвлөх, хэрэгжүүлэх; - Хүрээлэн байгаа орчны болон ундны усны цацрагийн түвшний хяналт шинжилгээ хийх, тэдгээр нь хүний эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэх эсэхийг тогтоох, урьдчилан сэргийлэх арга хэмжээнд хяналт тавих, мэдээллээр хангах; - Цацрагийн аюулгүй байдлыг хангах, аюулгүйн дүрэм, журам, стандартыг мөрдүүлэх; - Холбогдох байгууллагатай хамтран газар орны цацрагийн түвшний өөрчлөлт, агаар, хөрс, усан дахь цацрагийн бохирдолт болон өөрчлөлтөд хяналт тавих, мэдээллээр хангах; - Цацрагийн аюул, эрсдэлээс урьдчилан сэргийлэх мэдээ, мэдээллийг олон нийтэд хэвлэл, мэдээллийн хэрэгсэл, олон нийтийн цахим сүлжээ, багц мессежээр хүргэх; - Гамшгаас хамгаалах тухай хуулийн 33 дугаар зүйлд тусгагдсан чиг үүргийг хэрэгжүүлэх. 	Цөмийн энергийн комисс (ЦЭК)
20.	<ul style="list-style-type: none"> - Гамшгийн үед шаардлагатай бараа, материал, хүмүүнлэгийн тусламжийг улсын хилээр түргэн шуурхай нэвтрүүлэх боломжийг бүрдүүлэх; - Улсын хилийн боомт, гүний гаалийн хяналтын бүсэд нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдал (хүн, мал амьтны халдварт өвчин, цацраг, химийн осол) үүсэхээс урьдчилан сэргийлэх; 	Гаалийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага (ГАЭТЗБ)
21.	<ul style="list-style-type: none"> - Гамшиг, ослын голомт болон хорио цээрийн бүсэд хамгаалалт зохион байгуулах хүч хэрэгслийн бэлтгэлийг хангах; - Цацраг, хими, биологи, тэсэрч дэлбэрэх бодисын хууль бус хэрэглээтэй холбоотой асуудлыг мөрдөн шалгаж, урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах; - Гамшгийн үед нийтийн хэв журам сахиулах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох арга хэмжээг урьдчилан төлөвлөх; - Гамшгаас хамгаалах тухай хуулийн 33 дугаар зүйлд тусгагдсан чиг үүргийг хэрэгжүүлэх. 	Цагдаагийн төв байгууллага (ЦТБ)
22.	<ul style="list-style-type: none"> - Гамшгийн үед түр нүүлгэн шилжүүлсэн иргэд, аюулгүйн талбайд цугласан иргэдэд улсын бүртгэлийн үйлчилгээг шуурхай хүргэх бэлтгэлийг хангах. 	Улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага (УБАЭТЗБ)



23.	<ul style="list-style-type: none">- Орон нутгийн хөгжлийн бодлого, төлөвлөлтөд гамшгийн эрсдэлийг тооцох, Засаг даргын мөрийн хөтөлбөрт гамшгаас хамгаалах арга хэмжээг тусгах;- Засаг захиргаа нутаг дэвсгэрийн хэмжээнд гамшгийн эрсдэлийн ерөнхий үнэлгээ хийх;- Гамшгийн эрсдэлийн үнэлгээнд тулгуурлан гамшгийн эрсдэлийг бууруулах, урьдчилан сэргийлэх арга хэмжээг төлөвлөх, хэрэгжүүлэх;- Нэгдсэн Үндэсний Байгууллагын Гамшгийн эрсдэлийг бууруулах газраас хэрэгжүүлж буй “Аюулгүй, гамшигт тэсвэртэй хот” хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээг төлөвлөж хэрэгжүүлэх;- Ашиглалтын шаардлага хангахгүй барилгыг хүчитгэх, буулгаж шинээр барих ажлыг төлөвлөх, холбогдох зардлыг үе шаттай төсөвт тусгах, хэрэгжүүлэх;- Гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд шаардагдах хөрөнгийн эх үүсвэр, гамшгаас хамгаалах болон орон нутгийн нөөцийг бүрдүүлэх;- Иргэдийн гамшгаас хамгаалах сургалт, арга зүйн төвийг байгуулах, иргэд олон нийтэд гамшгаас хамгаалах мэдлэг, дадлага олгох ажлыг зохион байгуулах;- Харилцаа холбоо, зарлан мэдээлэх системийн байнгын бэлэн байдлыг хангах;- Иргэдийг нүүлгэн шилжүүлэх, түр цугларах талбай, түр байрыг томилгоожуулах, бэлтгэх, газрын баталгаажуулалтад хяналт тавих;- Орон нутгийн хэвлэл, мэдээллийн хэрэгслээр гамшгийн эрсдэлийг бууруулах, урьдчилан сэргийлэх сэрэмжлүүлэг мэдээлэл, сурталчилгааг иргэдэд хүргэх ажлыг зохион байгуулах;- Цацраг, хими, биологи, тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийг үйлдвэрийн болон хадгалах байр, агуулахад тогтоосон аюулгүйн бүсийн хил хязгаарт иргэд болон аж ахуйн нэгж, байгууллагад газар олгохгүй байх;- Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлд заасан чиг үүрэг, 51.2 дахь хэсэгт заасныг хэрэгжүүлэх.	Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга
24.	<ul style="list-style-type: none">- Гамшгийн үед хамтран ажиллах чиглэлийг урьдчилан төлөвлөх;- Гамшгийн эрсдэлийг бууруулах арга хэмжээг төлөвлөх, хэрэгжүүлэх;- Гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд шаардлагатай шинжлэх ухааны судалгаа, мэдээллээр хангах;- Гамшгийн үед дэмжлэг үзүүлэх хүч хэрэгслийн бэлэн байдлыг хангах, томилгоожуулах.	Шинжлэх ухааны байгууллага, их, дээд сургуулиуд



25.	<ul style="list-style-type: none"> - Гамшгаас хамгаалах тухай хуулийн 34 дүгээр зүйлд заасан чиг үүрэг, 51.2 дахь хэсэгт заасныг хэрэгжүүлэх; - Өөрийн байгууллагын аюулгүй байдлыг шалгах, энэ чиглэлээр холбогдох албан тушаалтныг томилох, үйл ажиллагаанд нь хяналт тавих; - Байгууллагын гал түймэр, гамшгийн аюулгүй байдлыг хангах, энэ чиглэлээр мэргэжлийн байгууллагатай хамтран ажиллах; - Гамшгаас хамгаалах нөөц бүрдүүлэх, гамшгийн үед байгууллагын үйл ажиллагааг хэвийн явуулах нөхцөлийг бүрдүүлэх. 	Бусад хуулийн этгээд
-----	---	----------------------

Гурав.Гамшгаас хамгаалах бэлэн байдлыг хангах арга хэмжээ

Үндэслэл:Гамшгаас хамгаалах тухай хуулийн 10, 13, 33, 34, 37 дугаар зүйл.

3.1.Гамшгаас хамгаалах бэлэн байдлыг хангах:

3.1.1.Энэ төлөвлөгөөний 2.1-д заасан арга хэмжээг хэрэгжүүлэх байгууллагууд бэлэн байдлыг хангах дараах нийтлэг арга хэмжээг хэрэгжүүлнэ;

№	Бэлэн байдлыг хангах арга хэмжээ	Зохион байгуулж хэрэгжүүлэх
1.	<ul style="list-style-type: none"> - Гамшгийн хариу арга хэмжээг зохион байгуулах томилгоот хүч хэрэгсэл (хүн, техник, багаж, тоног төхөөрөмж, зэвсэглэмж, хамгаалах хэрэгсэл)-ийн судалгааг гаргах, тодотгох, бэлэн байдлыг хангах, тэдгээрийг дайчлах боломжийг бүрдүүлэх; - Харилцаа холбоо, зарлан мэдээлэх хэрэгслийн бэлэн байдлыг хангах, мэдээ, мэдээлэл солилцох боломж бүрдүүлэх; - Ажилтан, албан хаагчдад гамшгийн зарлан мэдээллийн дохио дамжуулах, түргэн цугларах бэлтгэл хангах, дадлага сургууль зохион байгуулах; - Гамшгийн үед байгууллагад ашиглагдах бүх төрлийн нөөц (хүнс, шатах тослох материал, бараа материал, бусад) бүрдүүлэх; - Ажилтан, алба хаагч нарыг гамшгийн үед ажиллах шуурхай штаб, мэргэжлийн анги, бүлэг, хэсгүүдэд томилгоожуулж, сургаж дадлагажуулах; - Салбар дундын төлөвлөгөө, мэдээ, мэдээлэл солилцох, хамтран ажиллах төлөвлөлтийг урьдчилан боловсруулж батлуулах; - Удирдах бүрэлдэхүүн гамшгаас хамгаалах талаарх хууль, эрх зүйн мэдлэг болон гамшгийн үед шийдвэр гаргах чадвар эзэмших; 	Байгууллагын удирдлага

	- Ажилтан, алба хаагчдыг хөдөлмөр хамгааллын хувцас хэрэглэл, хээрийн үүргэвчээр хангах.	
2.	- Гамшгийн үед өөрийгөө болон бусдыг аврах, анхны тусламж үзүүлэх чадвар эзэмших; - Аюулгүйн талбай, түр цугларах цэг, түр амьдрах байрныхаа талаар мэдлэг эзэмших; - Мэргэжлийн ангид томилогдсон бүрэлдэхүүн гамшгийн үед холбогдох хариу арга хэмжээг хэрэгжүүлэх чадвар эзэмших; - Гамшгаас хамгаалах тухай хуулийн 37 дугаар зүйлд заасан чиг үүргийг хэрэгжүүлэх.	Ажилтан, алба хаагчид

3.1.2.Гамшгийн үед тухайн шатны Онцгой комисс, төв, орон нутгийн Онцгой байдлын байгууллагаас тогтоосон газарт, заасан хугацаанд, томилгоот хүч хэрэгслийг бэлэн байлгах, техник, багаж хэрэгсэл, хүн нэг бүрийн хамгаалах хэрэгсэл, хөдөлмөр хамгааллын хувцсаар хангах үүргийг яам, агентлаг, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллага хүлээнэ;

3.1.3.Онцгой байдлын ерөнхий газрын даргын тушаалаар баталсан “Гамшгаас хамгаалах бэлэн байдлыг хангах үзлэг, шалгалт явуулах, үнэлэх журам”-ын дагуу Гамшгаас хамгаалах алба, яам, агентлаг, аж ахуйн нэгж, байгууллагын бэлэн байдлыг Онцгой байдлын байгууллагаас үнэлж дүгнэнэ.

3.2.Гамшгаас хамгаалах сургалт:

3.2.1.Онцгой комисс, Гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн анги, хуулийн этгээдийн удирдлага, ажилтан, албан хаагч, сайн дурын хэсэг, иргэдийн гамшгаас хамгаалах бэлэн байдлыг хангах зорилгоор гамшгаас хамгаалах сургалтыг зохион байгуулна;

3.2.2.Аймаг, нийслэл, сум, дүүргийн онцгой комисс, гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн анги, хуулийн этгээд, гамшгаас хамгаалах сайн дурын хэсэг, иргэний сургалтыг тухайн шатны Засаг дарга орон нутгийнхаа онцгой байдлын байгууллага, мэргэжлийн холбоод, олон улсын байгууллагатай хамтран зохион байгуулна;

3.2.3.Улсын хэмжээнд гамшгаас хамгаалах стратегийн команд штабын сургуулийг дөрвөн жилд 1 удаа, гамшгаас хамгаалах улсын алба, яам, агентлагт гамшгаас хамгаалах команд штабын сургуулийг жилд 2-оос доошгүй удаа, Гамшгаас хамгаалах улсын алба, яам, агентлагт гамшгаас хамгаалах иж бүрэн сургуулийг жилд 1-ээс доошгүй удаа, онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хариуцан зохион байгуулна;

3.2.4.Гамшгаас хамгаалах алба, яам, агентлаг гамшгаас хамгаалах иж бүрэн болон команд штабын сургуулийг бие даан 4 жилд нэг удаа, байгууллага хооронд 2 жилд нэг удаа зохион байгуулна;

3.2.5.Бүх шатны боловсролын байгууллага гамшгаас хамгаалах сургалтыг хөтөлбөр, хуваарьт тусган, насны онцлогт тохируулан, тогтмол зохион байгуулна.

Дөрөв.Гамшгийн үеийн зохион байгуулалт, удирдлага

Үндэслэл:Гамшгаас хамгаалах тухай хуулийн 22, 25, 25¹, 26, 27¹, 28, 29, 30, 32, 33 дугаар зүйл.

4.1.Гамшгийн үеийн зохион байгуулалтын арга хэмжээ.

4.1.1.Стратегийн түвшинд (Үндэсний аюулгүй байдлын зөвлөл, Улсын Их Хурал, Засгийн газар, Улсын онцгой комисс, Онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, Гамшгаас хамгаалах улсын алба):

-Шаардлагатай тохиолдолд Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн хуралдаанаар гамшиг, гамшгийн онцгой нөхцөл байдал үүссэн асуудлыг шуурхай хэлэлцэж, Улсын Их Хурал, Засгийн газарт чиглэл, зөвлөмж гаргах;

-Гамшгийн хариу арга хэмжээг хэрэгжүүлэх чиглэлээр Засгийн газар, Улсын онцгой комиссын тогтоол, шийдвэр гаргах;

-Гамшгийн хариу арга хэмжээг хэрэгжүүлэхэд яам, агентлаг, аймаг, нийслэлийн Засаг даргыг удирдлагаар хангах;

-Гамшгийн үед тохиолдож болзошгүй эрсдэлийг урьдчилан тооцож, эрсдэлийг бууруулах арга хэмжээг хэрэгжүүлэх;

-Гамшиг, гамшгийн онцгой нөхцөл байдлыг зарлах, түүний эсрэг авч хэрэгжүүлэх хариу арга хэмжээний талаар хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд мэдээлэх;

-Хүч хэрэгсэл дайчлан гаргах, нүүлгэн шилжүүлэх шийдвэр гаргах;

-Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх, энэ үед хэрэгжүүлэх арга хэмжээний чиглэлийг тогтоох, холбогдох хөрөнгийг шийдвэрлэх;

-Аймаг, нийслэлийн Онцгой комисс, гамшгаас хамгаалах албаны харилцан ажиллагааг уялдуулан зохицуулах, хүч хэрэгслийг хуваарилах;

-Гамшгаас хамгаалах арга хэмжээг улсын хэмжээнд удирдлага, зохицуулалтаар хангах шуурхай штабыг байгуулах, орон нутагт шуурхай бүлгийг томилж ажиллуулах;

-Олон улсын хүмүүнлэгийн тусламж, эрэн хайх аврах баг хүлээн авах асуудлыг шийдвэрлэх, зохион байгуулах;

-Гамшгийн хариу арга хэмжээнд төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагын хүч хэрэгслийг татан оролцуулах.

4.1.2.Оперативын түвшинд (Аймаг, нийслэлийн Засаг дарга, Онцгой комисс, Онцгой байдлын газар, Гамшгаас хамгаалах орон нутгийн алба):

-Гамшгаас хамгаалах төлөвлөгөөг тодотгох, хэрэгжүүлэх;

-Аймаг, нийслэлийн онцгой комиссын Шуурхай штабыг байгуулж, гамшгийн хариу арга хэмжээг зохион байгуулах;

-Монгол Улсын Засгийн газар, Улсын онцгой комиссоос гарсан шийдвэр, өгсөн үүрэг чиглэлийг хэрэгжүүлэх, тайлагнах;

-Сум, дүүргийн онцгой комиссын харилцан ажиллагааг уялдуулан зохицуулах;

-Аймаг, нийслэлийн гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн ангийг удирдлага, зохицуулалтаар хангах;

-Сум, дүүргийн Онцгой комисс, гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн ангийн үйл ажиллагааг уялдуулах, харилцан ажиллагааг зохион байгуулж, удирдлага зохицуулалтаар хангах;

-Улсын онцгой комиссын Шуурхай штабыг мэдээ, мэдээллээр хангах, санал боловсруулан танилцуулах, шийдвэрлүүлэх;

-Орон нутгийн нөөц бүрдүүлэх, дотоодын хүмүүнлэгийн тусламжийг зохион байгуулах, хуваарилах;

-Хүч хэрэгслийн бэлэн байдлыг хангах, үүрэг гүйцэтгүүлэх;

-Аймаг, нийслэлийн түвшинд иргэн, хуулийн этгээдийг гамшгийн хариу арга хэмжээнд дайчлан гаргах арга хэмжээг хэрэгжүүлэх.



4.1.3.Тактикийн түвшинд (Сум, дүүргийн Онцгой комисс, мэргэжлийн анги, хуулийн этгээд, иргэн):

-Гамшгаас хамгаалах төлөвлөгөөг тодотгох, хэрэгжүүлэх;

-Сум, дүүргийн онцгой комиссын Шуурхай штабыг байгуулж, гамшгийн хариу арга хэмжээг зохион байгуулах;

-Улсын болон аймаг, нийслэлийн онцгой комиссоос гаргасан шийдвэр, өгсөн үүрэг чиглэлийг тухай бүр хэрэгжүүлэх;

-Гамшиг, ослын эрсдэлийг бууруулах, гамшгийн хариу арга хэмжээг төлөвлөн зохион байгуулах, шуурхай бүлгийг томилж ажиллуулах;

-Аймаг, нийслэлийн Онцгой комиссын Шуурхай штабыг бодит мэдээ, мэдээллээр хангаж, шийдвэрлүүлэх асуудлыг тухай бүр нь танилцуулах;

-Сум, дүүргийн мэргэжлийн ангийг удирдлага, зохицуулалтаар хангах;

-Гамшгаас хамгаалах чиглэлээр гарсан бүх төрлийн шийдвэрийг иргэдэд хүргэх, таниулах;

-Улсын, орон нутгийн нөөц болон хүмүүнлэгийн тусламж хүсэх, холбогдох тооцоо, судалгаа гаргаж, аймаг, нийслэлийн Онцгой комисст хүргүүлж, хуваарилсан нөөцийг үр дүнтэй зарцуулж, хяналт тавьж, тайлагнах;

-Гамшгийн хариу арга хэмжээнд иргэн, хуулийн этгээдийг дайчлан гаргах арга хэмжээг хэрэгжүүлэх.

4.2.Гамшгийн үеийн удирдлага зохицуулалт.

№	Гамшиг, аюул үзэгдлийн төрөл	Удирдан зохицуулах	Зохион байгуулж хэрэгжүүлэх	Дэмжлэг үзүүлж хамтран ажиллах байгууллага
1.	Газар хөдлөлт	УОК, ОБАЭТЗБ	ГХУА	Төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллага, аж ахуй нэгж, байгууллага, иргэн
2.	Хүний гоц халдварт өвчин, цар тахал		ЭМАЭТЗТБ, ГХУА	
3.	Зуд		ХХАААЭТЗТБ, ГХУА	
4.	Үер		ГХУА	
5.	Ой, хээрийн түймэр	ОБАЭТЗБ	ГХУА	
6.	Мал, амьтны гоц халдварт өвчин	УОК, ОБАЭТЗБ	ХХАААЭТЗТБ, ГХУА	

Тав.Гамшгийн хариу арга хэмжээ

Үндэслэл:Гамшгаас хамгаалах тухай хуулийн 15, 25, 25¹, 26, 27¹, 28, 29, 32, 33 дугаар зүйл, Монгол Улсын Шадар сайдын тушаалаар батлагдсан “Гамшгаас хамгаалах улсын алба тэдгээрийг түшиглэн ажиллах төрийн захиргааны байгууллагын жагсаалт, чиг үүрэг, гамшгаас хамгаалах улсын албаны ажиллах журам”.

5.1.Аж ахуйн нэгж, байгууллагад үүссэн гамшгийн хариу арга хэмжээг тухайн байгууллагын гамшгаас хамгаалах төлөвлөгөөгөөр, сум, дүүргийн нутаг дэвсгэрт үүссэн гамшгийн хариу арга хэмжээг сум, дүүргийн гамшгаас хамгаалах төлөвлөгөөгөөр, хоёр ба түүнээс дээш сум, дүүргийн нутаг дэвсгэрт үүссэн гамшгийн хариу арга хэмжээг аймаг, нийслэлийн гамшгаас хамгаалах төлөвлөгөөгөөр, улсын хэмжээнд болон хэд хэдэн аймаг, нийслэлд үүссэн гамшгийн хариу арга хэмжээг Монгол Улсын гамшгаас хамгаалах төлөвлөгөөгөөр тус тус удирдан зохион байгуулна.

Монгол Улсын гамшгаас хамгаалах төлөвлөгөөний салбар төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардагдах хүч хэрэгслийг Онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага жил бүрийн 1 дүгээр улиралд багтаан тодотгоно.

5.2.Төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагууд Монгол Улсын Засгийн газрын тогтоолоор батлагдсан “Харилцан ажиллагааны төлөвлөгөө”-ний дагуу гамшгийн хариу арга хэмжээнд оролцоно.

5.3.Гамшгийн үед хэрэгжүүлэх нийтлэг арга хэмжээ.

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Удирдлагаар хангах байгууллага	Хэрэгжүүлэх хугацаа	Дэмжлэг үзүүлэх байгууллага
Стратегийн түвшинд хэрэгжүүлэх арга хэмжээ				
1.	Гамшгийн нөхцөл байдлыг дараалал харгалзахгүйгээр нэн яаралтай хэлэлцэж, хууль, бусад шийдвэрийг гаргах	УИХ	Тухай бүр	ЗГ, ОБАЭТЗБ
2.	Гамшгийн нөхцөл байдлыг шуурхай хэлэлцэж, Улсын Их Хурал, Засгийн газарт зөвлөмж, чиглэл өгөх	ҮАБЗ		
3.	Онц байдал зарлах, цуцлах шийдвэр гаргах	УИХ, Монгол Улсын Ерөнхийлөгч		УОК, ОБАЭТЗБ
4.	Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх болон цуцлах шийдвэр гаргах	Засгийн газар		



5.	Гамшгийн үед түр орон байраар хангах, нүүлгэн шилжүүлэх шийдвэр гаргах	12 цагийн дотор	ХБАЭТЗТБ, ЗТХАЭТЗТБ
6.	Гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд нэмэлт хүч хэрэгсэл дайчлан гаргах		БХАЭТЗТБ, ХЗАЭТЗТБ, ЗХЖШ, ХХАЭТЗБ, ОБАЭТЗБ
7.	Гамшгийн үед төрийн цэргийн байгууллагын зарим анги, салбарыг оролцуулах шийдвэрийг зэвсэгт хүчний ерөнхий командлагчийн зөвшөөрснөөр гаргах	Тухай бүр	СТАЭТЗТБ, ХЗАЭТЗТБ, ХХАААЭТЗТБ, ГХАЭТЗБ, ОБАЭТЗБ
8.	Гамшгийн үед шаардлагатай хөрөнгийг шийдвэрлэх		
9.	Гамшгийн үед нийгэм, эдийн засгийн тогтвортой байдлыг хангах, төрийн үйлчилгээг тасралтгүй явуулах	12 цагийн дотор	СТАЭТЗТБ, ХЗАЭТЗТБ, ХХАААЭТЗТБ, ГХАЭТЗБ, ОБАЭТЗБ
10.	Гамшгийн үеийн хариу арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардлагатай хүнс, бараа, материалын нөөцийг бүрдүүлэх, холбогдох зардлыг шийдвэрлэх		
11.	Олон улсын болон дотоодын хүмүүнлэгийн тусламжийн арга хэмжээг зохион байгуулах шийдвэр гаргах	48 цагийн дотор	
12.	Худалдаа, үйлдвэрлэл, нийтийн үзвэр, үйлчилгээний газар, боловсролын байгууллагын үйл ажиллагаа, нийтээр тэмдэглэдэг баярын өдрүүдийг бүрэн болон хэсэгчилсэн байдлаар түр зогсоох, эсхүл түүгээр нэвтрэх хөдөлгөөнийг хязгаарлах шийдвэр гаргах	Тухай бүр	Яам, агентлаг
13.	Хилийн боомтод тусгай дэглэм тогтоож, мөрдүүлэх		ХЗАЭТЗТБ, ГХАЭТЗТБ, ХХАЭТЗБ, ГАЭТЗБ
14.	Монгол Улсаас нутаг буцах хүсэлтэй гадаадын иргэдийг буцаах ажиллагааг төлөвлөх, зохион байгуулах		ЭМАЭТЗТБ, ХХАААЭТЗТБ, ОБАЭТЗБ
15.	Нэн шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгсэл, ороох боох материал, цус, цусан бүтээгдэхүүн, хоол, хүнс, шатах тослох материал болон бусад шаардлагатай бүтээгдэхүүний нөөцийг нэмэгдүүлэх		



16.	Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн үед Засгийн газраас тогтоосон чиглэлийн хүрээнд ГХтХ 10 дугаар зүйлийн 10.4 болон 10.7 дахь хэсэгт заасан арга хэмжээг хэрэгжүүлэх, хяналт тавих	УОК	6 цаг тутамд	ГХУА, Яам, агентлаг
17.	Гамшгийн үед тухайн холбогдсон асуудлаар тогтоол, албан даалгавар, тушаал гаргах			
18.	Гамшгийн нөхцөл байдлын талаар болон авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээг ҮАБЗ, Засгийн газарт танилцуулах			
19.	Гамшгаас хамгаалах арга хэмжээг улсын хэмжээнд удирдан зохион байгуулах шуурхай штабыг байгуулах орон нутагт шуурхай бүлгийг томилох			
20.	Гамшгийн үед аж ахуйн нэгж байгууллагын эзэмшлийн эд хөрөнгө, барилга байгууламжийг нөхөн олговортойгоор дайчлан гаргах	ЗГ, Тухайн шатны ЗД	Нэн даруй	ХБАЭТЗТБ
21.	Гамшигт нэрвэгдсэн иргэдийг түр орон байраар хангах			
22.	Нэн тэргүүнд эрэмбэлэгдсэн байгууламжуудыг цахилгаан, дулаанаар хангах			
23.	Бэлэн байдлын зэрэгт шилжсэн үед авч хэрэгжүүлэх арга хэмжээний түр журам боловсруулах, хэрэгжүүлэх	УОК		Яам, агентлагууд
24.	Төрийн болон төрийн өмчит байгууллагын үүрэг, зориулалт, хөдөлмөрийн нөхцөлийг өөрчлөх ажлын тусгай горимд шилжүүлэх			
25.	Хүний эрх, эрх чөлөөг хангах арга хэмжээнд хамтран ажиллах, зөвлөгөө өгөх, хяналт тавих, дүгнэлт гаргах	ХЭҮК	Тухай бүр	УОК
26.	Гамшгийн аюулын зарлан мэдээллийг иргэдэд шууд дамжуулах	ОБАЭТЗБ	Нэн даруй	ХХАЭТЗТБ, хэвлэл мэдээллийн байгууллага
27.	Хөдөлгөөнт болон суурин шуурхай штаб байгуулах	ГХУА		ОБАЭТЗБ



28.	Үүссэн нөхцөл байдлын мэдээ, мэдээллийг иргэд, олон нийтэд хүргэх	ЗГХЭГ	Хэвлэл мэдээллийн байгууллага
29.	Гамшигтай холбоотой мэдээ, мэдээллийг дараалал харгалзахгүй хүлээн авч дамжуулах	ХХАЭТЗТБ	
30.	Гамшгийн үед интернэт, сүлжээ, холбоо харилцааны тоног төхөөрөмжийг бэлтгэх, харилцаа холбоог зохион байгуулах		ОБАЭТЗБ
31.	Гамшиг, аюулт үзэгдэл, ослын мэдээллийг цуглуулж, нөхцөл байдлыг үнэлэн үүссэн нөхцөл байдлын мэдээллийг байгууллагуудад дамжуулах	ОБАЭТЗБ	
32.	Гамшгийн голомтод эрэн хайх, аврах, гал түймэр унтраах ажиллагааг зохион байгуулах		ЭМАЭТЗТБ
33.	Гамшигт нэрвэгдэгсдэд эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэх	ЭМАЭТЗТБ	
34.	Хүний гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, тэмцэх ажлыг зохион байгуулах		ЦТБ
35.	Хээрийн эмнэлэг дэлгэх, шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмж, цус, цусан бүтээгдэхүүний нөөцийг гаргах	ЦТБ	
36.	Гэмт хэрэг, зөрчил, нийтийн хэв журам хамгаалах, дэг журам сахиулах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах		ЦТБ
37.	Гамшгийн голомт болон хорио цээрийн бүсэд хамгаалалт зохион байгуулах, эргүүл, хяналтыг томилон аливаа гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, зорчих хөдөлгөөнийг хязгаарлах	ЦТБ	
38.	Нийтийн эмх замбараагүй байдлыг таслан зогсоох		БОАЭТЗТБ
39.	Нүүлгэн шилжүүлсэн, аюулгүйн талбайд түр гарсан иргэдийн орон байр, өмч хөрөнгийг хамгаалах	БОАЭТЗТБ	
40.	Байгаль, цаг агаарын гамшигт болон аюулт үзэгдлийн тухай урьдчилсан мэдээ, мэдээлэл гаргах, олон нийтэд мэдээлэх		БОАЭТЗТБ
41.	Сансрын хиймэл дагуулын үзэгдлийн зураглал гаргах, олон нийт, иргэдэд мэдээлэх		



42.	Гамшгаас хамгаалах алба, шуурхай штаб байгууллага хоорондын холбоо зохион байгуулах нөхцөлийг бүрдүүлэх, дэмжлэг үзүүлэх	ХХАЭТЗТБ	Нэн даруй	Яам, агентлагууд, Аймаг, нийслэл, сум дүүргийн Засаг дарга, ҮХОК
43.	Хүнд машин механизмаар нуранги зайлуулах, зам, гарцыг чөлөөлөх	АҮЭБАЭТЗТБ		ЗТХАЭТЗТБ, ХБАЭТЗТБ, ЗХЖШ
44.	Хүч хэрэгсэл дайчлан гаргах арга хэмжээг зохион байгуулах	Аймаг, нийслэл, сум дүүргийн Засаг дарга	24 цагийн дотор	ОБАЭТЗБ
45.	Голомтын бүсээс хүн, мал, амьтан, эд хөрөнгийг түр нүүлгэн шилжүүлэх	Аймаг, нийслэл, сум дүүргийн Засаг дарга		ЗТХАЭТЗТБ, ОБАЭТЗБ, ТЦБХСБ
46.	Нүүлгэн шилжүүлэх үйл ажиллагаанд шаардагдах тээврийн хэрэгслээр хангах	ЗТХАЭТЗТБ		АҮЭБАЭТЗТБ, ХБАЭТЗТБ, ТЦБХСБ
47.	Нүүлгэн шилжүүлэх, түр байршуулах арга хэмжээг хэрэгжүүлэхдээ гэр бүлийн гишүүдийг салгахгүй байх, хүүхдийг эцэг эх, асран хамгаалагчтай хамт бүртгэлжүүлэх	ГБХНХАЭТЗТБ		ХЗАЭТЗТБ
48.	Голомтын бүс болон хорио цээр, хязгаарлалтын дэглэм тогтоох	Аймаг, нийслэл, сум дүүргийн Засаг дарга	Тухай бүр	ОБАЭТЗБ, ГХУА
49.	Байр зүйн болон план зураг, орон зайн өгөгдлөөр хангах	ГЗЗАЭТЗБ		ХБАЭТЗТБ
50.	Гамшгийн хариу арга хэмжээг нэгдсэн удирдлага, зохицуулалтаар хангах, голомтод хүч хэрэгслийг хуваарилах	ОБАЭТЗБ	Тухай бүр	Яам, агентлагууд, ТЦБХСБ
51.	Харилцан ажиллагааг зохион байгуулж мэдээ, мэдээлэл солилцох			
52.	Хоол, хүнс, цэвэр усаар хангах	ХХАААЭТЗТБ	Тухай бүр	БХАЭТЗТБ, ЗХЖШ, ОБАЭТЗБ, ГАЭТЗБ, МУЗН, ОУБ
53.	Хүнсний аюулгүй байдалд хяналт тавих			ХАБҮЛЛ
54.	Нэрвэгдэгсдэд сэтгэл зүйн тусламж үйлчилгээ үзүүлэх	ЭМАЭТЗТБ	Тухай бүр	СЭМҮТ



55.	Аюулгүйн талбайд цугласан иргэдийг бүртгэх, зааварчилгаа өгөх		УБАЭТЗБ	Нэн даруй	Аймаг, нийслэл, сум дүүргийн Засаг дарга
56.	Олон улсын эрэн хайх аврах баг, хүмүүнлэгийн тусламжийг хүлээн авах зохион байгуулалтын арга хэмжээг авах		ГХАЭТЗТБ, ОБАЭТЗБ		БХАЭТЗТБ, ГАЭТЗБ, ХАЭТЗБ, ГИХАЭТЗБ
57.	Төрийн тусгай хамгаалалтад байх байгууллагын хэвийн ажиллагаа, аюулгүй байдлыг хангах шаардлагатай арга хэмжээг авах		ДЦ	Нэн даруй	ТБ, ЗХЖШ, ХАЭТЗБ, ШШГБ
58.	Эвдэрсэн зам, гарц, гүүрийг засварлах		ЗТХАЭТЗТБ		ХБАЭТЗТБ, БХАЭТЗТБ, ЗХЖШ
59.	Хог хаягдлыг зайлуулах, ариутгал халдваргүйжүүлэлт хийх	Цацраг	ЦЭКАА		АҮЭБАЭТЗТБ, ГАЭТЗБ, ХАБУЛЛ, ЗХЖШ, ОБАЭТЗБ
		Хими	БОАЭТЗТБ		БХАЭТЗТБ, ОБАЭТЗБ
		Нуранги	Аймаг, нийслэл, сум дүүргийн Засаг дарга		ЗТХАЭТЗТБ, ХБАЭТЗТБ
Ахуйн	Харьяа байгууллагууд				
60.	Нэрвэгдсэн иргэдийн мэдээллийг гаргах		ОБАЭТЗБ	Яам, агентлаг, Аймаг, нийслэл, сум дүүргийн Засаг дарга	
61.	Гамшгийн нөөцийг хуваарилах, хангалтыг зохион байгуулах				
62.	Гамшигт өртсөн иргэдийн өргөдөл, гомдлыг хүлээн авах шуурхай шийдвэрлэх				
63.	Цогцос хадгалах байрны зохицуулалтын арга хэмжээ авах		ЭМАЭТЗТБ	Тухай бүр	Аймаг, нийслэл, сум дүүргийн Засаг дарга
64.	Гамшгийн улмаас нас барагсдыг таниулах, цогцос цуглуулах, зөөвөрлөх, түр хадгалах		ШШГБ		Аймаг, нийслэл, сум дүүргийн Засаг дарга
65.	Улсын нөөцөөс олгосон бараа, материал, дотоодын болон олон улсын хүмүүнлэгийн тусламжийг шаардлагатай газарт хүргэх, тээвэрлэх, хуваарилах		ОБАЭТЗБ		ЗТХАЭТЗТБ, ТЦБХСБ, Аймаг, нийслэл, сум дүүргийн Засаг дарга
66.	Нөөцийн бараа, материалыг тогтоосон байршил, нэр төрөл, тоо хэмжээнд бүрдүүлэх, хадгалах, шинэчлэх, Засгийн газрын шийдвэрийн дагуу улсын нөөцөөс бараа, материал гаргах, нөхөн бүрдүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах				СТАЭТЗТБ

67.	Нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай хүүхэд, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, эцэг эхийн хараа хяналтгүй хүүхдүүдийн судалгаа гаргах, шаардлагатай бүх талын тусламж үзүүлэх	ГБХНХАЭТЗТБ	Нэн даруй	БАЭТЗТБ, ЭМАЭТЗТБ, УБАЭТЗБ, МУЗН, Аймаг, нийслэл, сум дүүргийн Засаг дарга
68.	Гамшгийн үед хүүхдэд сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх ажлыг зохион байгуулах			УБАЭТЗБ, Аймаг, нийслэл, сум дүүргийн Засаг дарга
69.	Гамшигт нэрвэгдсэн иргэдийн өрхийн амьжиргааг дэмжих арга хэмжээг зохион байгуулах			ХЭУК
70.	Хүн амд, ялангуяа дохионы хэл зэрэг онцлог байдлаар харилцдаг хүмүүст тодорхой, хоёрдмол утга агуулгагүй, үнэн зөв мэдээллийг хүргэх, дэмжлэг үзүүлэх			
71.	Гамшгийн улмаас бичиг баримтгүй болсон иргэдийг шуурхай, хялбарчилсан байдлаар бичиг баримтжуулах, бичиг баримтгүйгээс шалтгаалан аливаа тусламж, үйлчилгээ авч чадахгүй байх эрсдэлийг бий болгохгүй байх	УБАЭТЗБ	Нэн даруй	ГБХНХАЭТЗТБ, ЦТБ
72.	Гамшигт өртөж сураггүй алга бологсдыг шалган тогтоох, эрэн сурвалжлах	ЦТБ		ЭМАЭТЗТБ, ТБ, ХАЭТЗБ, ШШГБ, УБАЭТЗБ, ГИХАЭТЗБ
73.	Улсын онц чухал объектууд, гадаад улсаас Монгол Улсад суугаа элчин сайдын яам, дипломат төлөөлөгчийн газруудын харуул хамгаалалтыг хүчитгэх			ДЦ, ЗХЖШ, ХАЭТЗБ
74.	Мал, амьтны сэг зэмийг устгах, ариутгал халдваргүйтгэл хийх	ХХАААЭТЗТБ		Тухай бүр
75.	Гадаад улсаас Монгол Улсад суугаа Элчин сайдын яам, дипломат төлөөлөгчийн газрууд, олон улсын байгууллагуудтай харилцан ажиллагааг зохион байгуулах мэдээлэл солилцох	ГХАЭТЗТБ	УОК	
76.	Эдийн засгийн хөгжлийн тогтвортой байдлыг хангах бодлого боловсруулах, хэрэгжүүлэх	ҮХБТАЭТЗТБ	СТАЭТЗТБ	



77.	Монгол Улсын хилээр шаардлагатай бараа, материал, гол нэрийн хүнсний бараа, эм, эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмж, ариутгал, халдваргүйжүүлэх бодис, гадаад улсын хүмүүнлэгийн тусламжийн барааг улсын хилээр шуурхай нэвтрүүлэх	ГАЭТЗБ	ГХАЭТЗТБ, ХАЭТЗБ, ГИХАЭТЗБ
78.	Гамшгийн хариу арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардлагатай хүнс, бараа, материалын нөөцийг бүрдүүлэх, холбогдох зардлыг шийдвэрлэх	СТАЭТЗТБ	Яам, агентлаг, Аймаг, нийслэл, сум дүүргийн Засаг дарга
79.	Хохирол хэрэгцээний үнэлгээнд үндэслэн шаардлагатай мөнгөн хөрөнгө зардлыг тооцох		
80.	Бүх шатны боловсролын байгууллагын дотуур байранд амьдарч буй суралцагчдын эрүүл мэнд, хоол хүнс, аюулгүй байдал, хүүхэд хамгааллын асуудалд анхаарах, цахим сургалт, мэдээллийг хүртээмжтэй явуулах	БАЭТЗТБ	ГБХНХАЭТЗТБ, Аймаг, нийслэл, сум дүүргийн Засаг дарга, Аймаг, нийслэл, сум дүүргийн Засаг дарга
81.	Боловсролын байгууллагын барилга байгууламжийг түр орон байраар ашиглах боломжийг бүрдүүлэх		
82.	Түр орон байраар хангагдсан сургуулийн болон сургуулийн өмнөх насны хүүхдүүдэд зориулж сургалтын үйл ажиллагааг зохион байгуулах		

5.4.Гамшгийн үед байгууллагуудын түвшинд авч хэрэгжүүлэх нийтлэг арга хэмжээ.

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хугацаа	Хэрэгжүүлэх байгууллага
1.	Байгууллагын хэмжээнд зарлан мэдээлэл дамжуулж, цуглах	01:30 дотор	Гамшгийн нөхцөл байдал үүссэн үед бүх байгууллагууд
2.	Гамшгаас хамгаалах төлөвлөгөөг хэрэгжүүлэх	Үүссэн нөхцөл байдлаас эхлэн	
3.	Үүссэн нөхцөл байдлын талаар мэдээлэл цуглуулах, нөхцөл байдлыг үнэлэх	1 цагийн дотор	
4.	Шуурхай штаб байгуулах	2 цагийн дотор	



5.	Байгууллагын хүч хэрэгслийг тодотгох, төвлөрүүлэх	4 цагийн дотор
6.	Байгууллагыг удирдлагаар хангах	2 цагийн дотор
7.	Нэн тэргүүнд хэрэгжүүлэх арга хэмжээг төлөвлөх	3 цагийн дотор
8.	Хариу арга хэмжээг хэрэгжүүлэх	Тухай бүр
9.	Мэргэжлийн анги, бүлгийг арга зүйгээр хангах, үйл ажиллагааг удирдан чиглүүлэх, оролцуулах	
10.	Байгууллагын үйл ажиллагааны тогтвортой байдлыг хангах	
11.	Байгууллагын хэмжээнд гамшгаас хамгаалах үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд шаардагдах төсвийг шийдвэрлэх, хэрэгжилтийг зохион байгуулах	Тухай бүр
12.	Дээд шатны байгууллага, удирдлагыг мэдээ мэдээллээр тасралтгүй хангах, мэдээлэл солилцох, харилцан ажиллагаа зохион байгуулах	4 цаг тутамд

Зургаа.Гамшгийн мэдээлэл дамжуулах

Үндэслэл:Гамшгаас хамгаалах тухай хуулийн 10, 16 дугаар зүйл, Засгийн газрын тогтоолоор баталсан “Гамшгийн аюулын тухай зарлан мэдээллийн дохио дамжуулах журам”.

6.1.Гамшиг, аюулт үзэгдэл, ослын мэдээллийг байгууллагуудад дамжуулах:


6.1.1.Онцгой байдлын ерөнхий газрын Шуурхай удирдлага зарлан мэдээллийн асуудал эрхэлсэн нэгж гамшиг, аюулт үзэгдэл, ослын тохиолдлын мэдээллийг Улсын онцгой комиссын дарга, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн Шуурхай удирдлагын нэгдсэн төв, Гамшгаас хамгаалах улсын албад, Төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагад хүргэнэ;

6.1.2.Төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагуудтай харилцан ажиллагааны холбоог харилцан ажиллагааны “Чиглэлийн төлөвлөгөө”-нд тусгагдсаны дагуу радио холбоо, тусгай хэрэглээний төрийн мэдээллийн нэгдсэн сүлжээг ашиглан зохион байгуулна;




6.1.3. Сансрын сүлжээ үүсгэгчээр мэдээлэл дамжуулах боломжгүй болсон тохиолдолд байгууллагууд биет холбоочныг томилгоожуулан мэдээлэл солилцоно. Биет холбоочны мэдээллийг жил бүрийн 6 дугаар сард тодотгоно.

6.2. Гамшгийн мэдээлэл дамжуулах бүдүүвч:



6.3. Гамшиг, аюулт үзэгдэл, ослын мэдээллийг иргэдэд дамжуулах:

6.3.1. Газар хөдлөлт, үер, хүчтэй салхи шуурганы гамшигийг амжиж анхааруулах бүдүүвч;



6.3.2.Онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага удирдан гамшгийн аюулын тухай зарлан мэдээллийг иргэд, олон нийтэд хүргэхдээ телевиз, радиогоор нэвтрүүлгийг тасалж, телевизээр улаан дэвсгэр дээр хар бичиглэлтэйгээр, зураг, дүрс бүхий байдлаар, радиогоор анхааруулга өгч шууд яриагаар дамжуулна;

6.3.3.Гамшгийн аюулын тухай зарлан мэдээллийг дуут дохиоллын цамхагаар дамжуулахдаа түгшүүрийн дохио болон шууд яриаг 3 минут үргэлжлэх, 30 секундийн завсарлах хугацаатайгаар 3 удаагийн давталтаар, электрон самбараар, богино бичилт бүхий мэдээллийг 160 тэмдэгтэд багтаан бүх нийтийн буюу хэсэгчилсэн байдлаар шууд болон шуурхай штабын удирдлагаас өгсөн үүрэг, чиглэлийн дагуу дамжуулна;

6.3.4.Гамшгийн аюулын тухай зарлан мэдээллийг үүрэн холбооны сүлжээгээр дамжуулан олон нийтэд хүргэхдээ урьдчилан бэлтгэсэн богино бичилт бүхий мэдээллийг 160 тэмдэгтэд багтаан нэгэн зэрэг дамжуулна.

Долоо.Хангалт зохион байгуулалт

Үндэслэл:Гамшгаас хамгаалах тухай хуулийн 33 дугаар зүйлд заасан “Гамшгаас хамгаалах албаны чиг үүрэг”, Монгол Улсын Шадар сайдын тушаалаар батлагдсан “Гамшгаас хамгаалах улсын алба тэдгээрийг түшиглэн ажиллах төрийн захиргааны байгууллагын жагсаалт, чиг үүрэг, гамшгаас хамгаалах улсын албаны ажиллах журам”.



7.1.Байгууллагын ажилтан, алба хаагчид гамшгийн нөхцөл байдал үүссэн үед хэрэглэх 3 хоногийн хүнсний нөөцтэй байх бөгөөд хээрийн үүргэвчинд урьдчилан бэлдсэн байна.

7.2.Гамшгийн үед байгууллагын удирдлагын шийдвэрээр байгууллага дотоод хангалтыг зохион байгуулна.

7.3.Гамшгийн үед улсын хэмжээний хангалтыг дараах байгууллагууд хэрэгжүүлнэ. Хэрэгжүүлэх арга хэмжээг байгууллага тус бүр гамшгаас хамгаалах төлөвлөгөөндөө нарийвчлан тусгаж төлөвлөсөн байна.

	Хангалтын төрөл	Хэрэгжүүлэх байгууллага	Хамтран хэрэгжүүлэх байгууллага
1.	Харилцаа холбооны техник хэрэгсэл	ХХАЭТЗТБ	Яам, агентлаг, ТЦБХСБ
2.	Газар зүйн мэдээллийн систем, зайнаас тандан судлах, орон зайн суурь өгөгдөл (гамшгийн үед байр зүйн зураг бэлтгэх, зургаар хангах)	ГЗЗАЭТЗБ	БОАЭТЗТБ
3.	Хүн эмнэлэг, эм эмнэлгийн хэрэгсэл, ороох боох материал, цус, цусан бүтээгдэхүүн	ЭМАЭТЗТБ	БХАЭТЗТБ, БАЭТЗТБ, ОБАЭТЗБ, МУЗН, ОУБ (сектор)
4.	Орон байр, дулаан хувцас, ариун цэвэр, эрүүл ахуйн хэрэгсэл	ХБАЭТЗТБ	БХАЭТЗТБ, БАЭТЗТБ, ГБХНХАЭТЗТБ, ОБАЭТЗБ, МУЗН, ОУБ (сектор), Аймаг, нийслэл, сум дүүргийн Засаг дарга
5.	Хоол, хүнс, цэвэр ус	ХХАААЭТЗТБ	БХАЭТЗТБ, ГХАЭТЗТБ, ГБХНХАЭТЗТБ, ОБАЭТЗБ, ГАЭТЗБ, МУЗН, ОУБ (кластер), НЗБ
6.	Үр тариа	ХХАААЭТЗТБ	ОБАЭТЗБ, Аймаг, нийслэл, сум дүүргийн Засаг дарга
7.	Өвс, тэжээл		
8.	Ариутгал, халдваргүйтгэлийн бодис, уусмал		
9.	Тээврийн хэрэгсэл	ЗТХАЭТЗТБ	ЭМАЭТЗТБ, ЗХЖШ, ОБАЭТЗБ, ИНАЭТЗБ, ХБАЭТЗТБ, АҮЭБАЭТЗТБ, УБТЗХНН
10.	Багаж, техник тоног төхөөрөмж, хэрэгсэл (техник хэрэгсэл, тусгай хувцас, хэрэглэл)	Гамшгаас хамгаалах алба, төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллага	
11.	Хүний нөөц (хүн хүч)		



12.	Түлш, шатахуун тосолгооны материал	АҮЭБАЭТЗТБ	ХЯ, ЗТХАЭТЗТБ, ИНАЭТЗБ, ЭХАЭТЗТБ, УБТЗХНН
13.	Цахилгаан, дулаан	ЭХАЭТЗТБ	БОАЭТЗТБ, ХБАЭТЗТБ, ХХАААЭТЗТБ, АҮЭБАЭТЗТБ
14.	Мал эмнэлэг, эм бэлдмэл, вакцин	МАЭМАЭТЗБ	Орон нутгийн мал эмнэлгийн газар
15.	Бэлэн мөнгө, түргэн хөрвөх хөрөнгө	СТАЭТЗТБ	Аймаг, нийслэлийн засаг дарга

Найм.Гамшгийн хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох арга хэмжээ

Үндэслэл:Гамшгаас хамгаалах тухай хуулийн 21 дүгээр зүйл.

8.1.Сэргээн босгох арга хэмжээг богино хугацааны буюу хойшлуулшгүй сэргээн босгох арга хэмжээ, урт хугацааны буюу нийгэм эдийн засгийг тогтворжуулах сэргээн босгох арга хэмжээ гэж ангилна.

8.2.Нийгэм, эдийн засгийг тогтворжуулах урт хугацааны сэргээн босгох арга хэмжээг хэрэгжүүлэхдээ хохирол хэрэгцээний үнэлгээнд тулгуурлан хүн ам, нийгэм, эдийн засаг, хүрээлэн буй орчны хэвийн нөхцөлийг хангах ажлыг төлөвлөж, зардал, төсвийг шийдвэрлэн хэрэгжүүлнэ.

8.3.Гамшгийн хор уршгийг арилгах, богино хугацааны хойшлуулшгүй сэргээн босгох үйл ажиллагааг хохирлын үнэлгээнд тулгуурлан хийнэ. Гамшгийн хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох ажиллагаа нь гамшгийн үед хүний амь нас, эрүүл мэнд, мал, амьтан, эд хөрөнгө, хүрээлэн буй орчинд учирсан хохирлыг арилгахад чиглэнэ.

8.4.Хүний амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангах, хэвийн амьдралдаа орох, хүний эрхийг хангахад чиглэсэн нийгмийн үйлчилгээ, дэд бүтцийг нэн тэргүүнд сэргээн босгоно.

8.5.Гамшгийн хор уршгийг арилгах, үүссэн нөхцөл байдалтай холбогдуулан хойшлуулшгүй сэргээн босгох үйл ажиллагааг Засгийн газар, тухайн шатны Засаг дарга төлөвлөн удирдан зохион байгуулна.

8.6.Гамшгийн эрсдэлийг бууруулах үндэсний болон орон нутгийн зөвлөл нь гамшгийн дараах сэргээн босгох арга хэмжээг оновчтой хэрэгжүүлэх, улс орны тогтвортой хөгжлийн бодлого, зорилтод уялдуулах бодлогын зөвлөмжийг гаргана.



8.7.Хойшлуулшгүй сэргээн босгох ажиллагаанд шаардагдах зардлыг улсын хэмжээнд Засгийн газар, орон нутгийн хэмжээнд тухайн шатны Засаг дарга шийдвэрлэнэ.

8.8.Шаардлагатай тохиолдолд Засгийн газрын тогтоолоор улсын нөөцөөс, орон нутагт тухайн шатны Засаг даргын шийдвэрээр орон нутгийн нөөцийг тус тус гаргана.

Ес.Төсөв, санхүү

Үндэслэл:Гамшгаас хамгаалах тухай хуулийн 51 дүгээр зүйл.

9.1.Монгол Улсын гамшгаас хамгаалах төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлыг дараах байдлаар санхүүжүүлнэ:

9.1.1.Гамшгаас хамгаалах тухай хуулийн 51 дүгээр зүйлд заасан зардал;

9.1.2.Олон улсын хандив, тусламж;

9.1.3.Улсын төсөв;

9.1.4.Засгийн газрын нөөц хөрөнгө;

9.1.5.Даатгал.

---o0o---




ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

АҮЭБАЭТЗТБ	Аж үйлдвэр, эрдэс баялгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага;
БОАЭТЗТБ	Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага;
БХАЭТЗТБ	Батлан хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага;
БАЭТЗТБ	Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага;
ГБХНХАЭТЗТБ	Гэр бүл, хөдөлмөр нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага;
ГАЭТЗБ	Гаалийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага;
ГЗЗАЭТЗБ	Геодези, зураг зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага;
ГИХАЭТЗБ	Гадаадын иргэн, харьяатын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага;
ГТАЭТЗБ	Газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага;
ГХУА	Гамшгаас хамгаалах улсын алба;
ГХАЭТЗТБ	Гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага;
ГЭБҮЗ	Гамшгийн эрсдэлийг бууруулах үндэсний зөвлөл;
ДЦ	Дотоодын цэрэг;
ЗГХЭГ-ХМОНХГ	Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах газар;
ЗТХАЭТЗТБ	Зам, тээврийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага;
ЗХЖШ	Зэвсэгт хүчний жанжин штаб;
ИНАЭТЗБ	Иргэний нисэхийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага;

МУЗН	Монголын улаан загалмайн нийгэмлэг;
МАЭМАЭТЗБ	Мал, амьтны эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага;
НЗБ	Нутгийн захиргааны байгууллага;
НОК	Нийслэлийн Онцгой комисс;
ОБАЭТЗБ	Онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага;
ОУБ	Олон улсын байгууллага;
ССАЖЗЯ	Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яам;
СОК	Сумын онцгой комисс;
СЭМҮТ	Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв;
СТАЭТЗТБ	Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага;
ТБНЗБ	Төрийн болон нутгийн захиргааны байгууллага;
ТБ	Тагнуулын байгууллага;
ТТХБ	Төрийн тусгай хамгаалалтын байгууллага;
ТЦБХСБ	Төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллага;
УИХ	Улсын Их Хурал;
УБАЭТЗБ	Улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага;
УБТЗХНН	Улаанбаатар төмөр зам, хувь нийлүүлсэн нийгэмлэг;
УОК	Улсын Онцгой комисс;
УАБЗ	Үндэсний аюулгүй байдлын зөвлөл;
ҮХОК	Үүрэн холбооны оператор компани;
ҮХБТАЭТЗТБ	Үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага;
ХАБУЛЛ	Хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа лаборатори;

ХЗАЭТЗТБ	Хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага;
ХБАЭТЗТБ	Хот байгуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага;
ХХАЭТЗТБ	Харилцаа, холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага;
ХХАААЭТЗТБ	Хүнс, хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага;
ХАЭТЗБ	Хилийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага;
ХЭҮК	Хүний эрхийн үндэсний комисс;
ЦЕК	Цөмийн энергийн комисс;
ЦТБ	Цагдаагийн төв байгууллага;
ШШГБ	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага;
ШШЕГ	Шүүх шинжилгээний ерөнхий газар;
ЭМАЭТЗТБ	Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага;
ЭМГ	Эрүүл мэндийн газар;
ЭХАЭТЗТБ	Эрчим хүчний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага.

---o0o---



Хаяг:

“Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн редакц
Улаанбаатар-14201, Төрийн ордон 124 тоот
И-мэйл: turiin_medecelel@parliament.mn

Утас: 262420

Хэвлэлийн хуудас: 2.5

Индекс: 200003

